



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 229,000,000 (хоёр зуун хорин есөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг "Засгийн газрын Автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн Захиргаа, удирдлагын газрын дарга Г.Даваадалай, "Засгийн газрын Автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн
~~02~~ дугаар тогтоолын хавсралт

Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
"Засгийн газрын авто бааз" улсын төсөвт үйлдвэрийн газарт
балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгсэл

№	Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)
1	Ниссан патрол Y62 ,0565УБЕ, (арал-JN8AY2NY1L9401763)	2020	150	229,000,000.00
	Нийт дүн			229,000.000.0 (хоёр зуун хорин есөн сая)